



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын хэрэгжилтэнд үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Үнэлгээг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хяналт –шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081219

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 9 сарын 7 өдрийн
346 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын хэрэгжилтэнд үнэлгээ хийх, ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
Аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Т.Баярсайхан, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Г.Базархүрэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
хариуцсан мэргэжилтэн

С.Эрдэнэтуяа, Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн
бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Ч.Амаржаргал, Эмийн сонголт, бүртгэл, эмнэлзүйн бодлогын
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

С.Отгонсүх, Анагаах ухааны технологийн бодлогын
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Д.Уранчимэг, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны
дарга

П.Эрхэмбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дотоодын
эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх,
зөвшөөрөл олгох, гэрчилгээ хариуцсан мэргэжилтэн

Я.Бадамсүрэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн гадаадын
мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх,
зөвшөөрөл олгох гэрчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 29 сарын 7 өдрийн
346 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж

Улаанбаатар хот

2015.08.27

1. Үндэслэл:

Эрүүл мэндийн сайдын 2015 оны “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн батласан 98 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах .


2. Зорилго:

Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын наймдугаар зүйлийн 8.2-т заасны дагуу хэрэгжилтэнд үнэлгээ хийж, хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмжөөр хангах

3. Үйл ажиллагааны чиглэл

- Хяналтын хүрээнд баримтын судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, уулзалт, ярилцлага хийх, холбогдох байгууллагын үйл ажиллагаа, журмын хэрэгжилттэй танилцах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын хэрэгжүүлэх арга хэмжээний 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зөвшөөрлийн зөвлөлийн ажлын албаны чиг үүргийн хэрэгжилт
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой гарсан өргөдөл гомдлын шийдвэрлэлт
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох үйл ажиллагааны болон Төрийн сангийн санхүүжилтээр явагдсан төгсөлтийн дараах сургалтын санхүүгийн тайлан
- Журмын шалгуур үзүүлэлтийн биелэлт, хүрсэн түвшинг тооцон, шалтгаан үр дүнд дүгнэлт хийнэ.

- Зарцуулсан санхүүжилт, үр дүнг тооцно
- Ололт амжилт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тусгасан тодорхой зөвлөмж боловсруулна
- Журмын хяналт-шинжилгээний тайланг эцэслэн Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулагдсан байна



Тухайн журмыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэнд үнэлгээ өгнө.

4. Хамрах хүрээ:

- Эрүүл мэндийн хөгжлийн төв

5. Хугацаа: 2015 оны 08-10 дугаар сар

6. Хүрэх үр дүн: Журмын хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж санал, зөвлөмж дэвшүүлсэн байна.

Хянасан : Э.Оюунсүрэн

Боловсруулсан: Б.Пүрэвсүрэн